



ТОГВОРТОЙ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖСЭН

**МОНГОЛ БАЗАЛТ ХК**  
ЖИЛ ИННОВАЦИ ТЕХНОЛОГИ



**2022**

**Монгол Базальт хувьцаат  
компанийн хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын материал**

## ❖ АГУУЛГА

- Гүйцэгэх захиралын мэндчилгээ
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар /ТУЗ-ийн тогтоол/
- Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар хугацаа
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
- Хурлаар хэлэлцэх асуудал
  1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
- Саналын хуудасны загвар
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл
- Ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоол
- Үйл ажиллагааны тайлан
- 2021 оны санхүүгийн тайлангийн Аудитын дүгнэлт

# Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



2020 оноос үргэлжилсэн Ковид-19 цар тахлын үр дагавар 2021 оны эхний улиралд дотоодын эдийн засаг, тэр дундаа барилга бүтээн байгуулалтын салбарын үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээлүүд бий болгосон ч 2021 оны эхний хагас жилийн дунд үеэс үйл ажиллагаанууд бага багаар сэргэж эхэлсэн билээ. "Монгол Базальт" ХК-ийн хувьд энэ хугацаанд ажилтануудаа тогтвортой ажлын байраар хангах, орлогын эх үүсвэр хангамжийг бууруулахгүй байх бодлогыг нэн тэргүүнд барьж ажилласан юм.

Компанийн хэвийн үйл ажиллагаанд эрсдэл үзүүлэх сөрөг хүчин зүйлүүд болох тээвэр ложистикийн хомсдол, дотоод болон гадаадын бараа материалын үнийн өсөлт, ААН-үүдийн төлбөрийн чадварын бууралт, томоохон төслүүдийн царцалт, валютын ханшийн өсөлт зэрэг асуудлуудтай олон сар нүүр тулсан хэдий ч бид онцгой цаг үеийн бодлого баримталж зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахаар барилгын дулаан тусгаарлагч байгальд ээлтэй чулуун хөвөн хавтан үйлдвэрлэж эхний хагас жилд 2020 оны үйлдвэрлэлтэй тэнцэх хэмжээний бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлсэн бол 8-11 сард 2021 оны нийт бүтээгдэхүүний 75%-ийг үйлдвэрлэсэн байна. Энэхүү үйлдвэрлэлийн өсөлт нь эхний улиралд хийгдсэн томоохон капитал хөрөнгө оруулалт болох хөвөн шарах камерийн технологийн шинэчлэлийн ажлын үр дүн байлаа.

Цаг үеийн нөхцөл байдалд зохицсон санхүү болон үйлдвэрлэл үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт хийн компанийн цаашдын үйл ажиллагааг тогтвортой байлгах бизнес төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл явуулахыг бид нэн тэргүүний зорилгоо болгон ажиллаж үйл ажиллагааны зардлаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16%-иар бууруулан, борлуулалтын орлогоо 3.5 дахин, цэвэр ашигаа 11.7 дахин тус тус өсгөсөн амжилттайгаар 2021 оныг үдлээ. Үндэсний цор ганц үйлдвэрлэгчийн хувьд бүтээгдэхүүний тоо хэмжээ, төрлүүд нэмэгдэж үүнийг дагаад санхүүгийн үр дүн үзүүлэлтүүд улам бүр сайжирч хэрэглэгчид болон нийт, хувьцаа эзэмшигчидийнхээ хүлээлтийг давуулан биелүүлэх боломж бүрдэнэ гэдэгт итгэлтэй байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

А.ЭНХГЭРЭЛ

## МОНГОЛ БАЗАЛТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ!

“Монгол Базальт” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж, батлахаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг бэлтгэн хувьцаа эзэмшигчдэд хүргүүлж байна.

Хувьцаа эзэмшигч та бүхнийг **2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 14.00 цагт** Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, үйлдвэрийн тойруу-132 тоот хаягт байрлах компанийн үйлдвэрийн байранд танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдах хуралд идэвхитэй оролцохыг урьж байна. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх **2022 оны 04-р сарын 03-ны өдөр** хүртэл бүртгэнэ.

Хурал зохион байгууллах комиссын гишүүдийн утас, электрон шуудангийн

хаяг: Утас: 7511-4444, 99804164

И-мэйл: mongolbasalt.tuz@gmail.com

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн жагсаалтууд:
1	“Монгол Базальт”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол
2	“Монгол Базальт”ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт
3	“Монгол Базальт”ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан
4	ТУЗ-ийн 2022 оны 03 сарын 10-ны өдрийн тогтоол, 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
5	Компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид, түүний хувьцааны төрөл, тоо
6	Ногдол ашиг тараах тухай 2022 оны 02 сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн тогтоол

Та бүхэн компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай 2022 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 11.00–16.00 цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэрын 7 давхарт байрлах компанийн оффис болон өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандан авах боломжтой.



## “МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03-р сарын 10-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дах заалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2, 6.3, 6.2, 6.4 дах заалтууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03-р сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 сарын 22-ны өдрийн Баасан гаригийн 14.00 цагт зарлан хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдааныг цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч цахим болон танхимын хэлбэрийг хослон явуулах бөгөөд Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн тойруу-132, Монгол базальт ХК-ийн үйлдвэрийн байранд зохион байгуулсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - “Монгол базальт” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 сарын 03-ны өдрөөр тогтоосугай.
5. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах хурлын зарыг 2022 оны 03 сарын 15-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, Компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын нэг сонин, радио, телевизийн аль нэгээр мэдээлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах давтан зарыг 2022 оны 03 сарын 30-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрээр өдөр тутмын сонин болон радио телевизийн аль нэгээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан бичиг баримтуудыг 7 хоног бүрийн ажлын өдрүүдийн 11.00-16.00 цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, “Фламинго тауэр”ийн 7 давхарт ирж танилцаж болох ба үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандах авах боломжтой болохыг дурьдсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх материал, энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан баримт бичгийг бэлэн болгох эцсийн хугацааг 2022 оны 03 сарын 17-ны өдрөөр тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал, хурлаас гаргах тогтоолын төсөл, түүнтэй холбоотой материалыг олон нийтэд хурлын зар хүргэснээс хойш 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигч нарт үйлчилж буй Үнэт цаасны компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралтаар баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй урьдчилан саналын хуудасаар санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудасыг хүлээн авах сүүлийн өдрийг 2022 оны 04 сарын 03-ны өдөрөөр тогтоосугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар А.Энхгэрэл, хурал зохион байгуулах комиссын гишүүдээр О.Билгүүн, Б.Амаржаргал нарыг тус тус томилсугай.
15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Ц.Байгалмаа, тооллогын комиссын гишүүдээр Б.Уранбилэг, Т.Ууганцэцэг нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ГИШҮҮД



Л.Ариунболд

Г.Ганзориг

А.Энхгэрэл

П.Сайнбилэг

Б.Шаравсамбуу

Хан Гю Бунг

Ш.Энхтөр

Ч.Зоригтбаатар

П.Нямдорж

“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2022 оны 03 сарын 10-ний өдрийн 4 тоот тогтоолын  
Хавсралт №3

## ❖ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

1. Хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэл, ирцийг мэдээлэх  
*15 минут*
  2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээх  
*10 минут*  

*/ ТУЗ-ийн дарга Л.Ариунболд /*
  3. Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу дараах илтгэлүүдийг тавина:
    - 3.1 Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлт, хурлаас гаргах тогтоол шийдвэрийн төслийг танилцуулах  
*20 минут*
    - 3.2 Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах  
*15 минут*
  4. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт  
*3 минут*
  5. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал  
*5 минут*
  6. Санал авах  
*10 минут*
  7. Санал хураалтын дүнг нэгтгэн, танилцуулах  
*10 минут*
  8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хурлын дарга танилцуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хаах  
*5 минут*
- Хурлын үргэжлэх хугацаа: *1 цаг 35 минут*

Жич: *Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.*

## ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



## “МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03 -р сарын 10 -ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Монгол базальт ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Компанийн дүрмийн 6-р бүлгийн 6.2.6.5 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА \_\_\_\_\_

Л.Ариунболд

ГИШҮҮД \_\_\_\_\_

Г.Ганзориг

А.Энхгэрэл

П.Сайнбилэг

Б.Шаравсамбуу

Хан Гю Бунг

Ш.Энхтөр

Ч.Зоригтбаатар

П.Нямдорж



### ❖ МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

“Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан компанийн дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

2021 онд Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Компанийн хэвийн үйл ажиллагаанд эрсдэл үзүүлэх сөрөг хүчин зүйлүүд болох тээвэр ложистикийн хомсдол, дотоод болон гадаадын бараа материалын үнийн өсөлт, ААН-үүдийн төлбөрийн чадварын бууралт, томоохон төслүүдийн царцалт, валютын ханшийн өсөлт зэрэг асуудлуудтай олон сар нүүр тулсан хэдий ч бид онцгой цаг үеийн бодлого баримталж зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахаар барилгын дулаан тусгаарлагч байгальд ээлтэй чулуун хөвөн хавтан үйлдвэрлэж эхний хагас жилд 2020 оны үйлдвэрлэлтэй тэнцэх хэмжээний бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлсэн бол 2021 оны эцэст бизнес төлөвлөгөөнд тусгасан үйлдвэрлэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. Энэхүү үйлдвэрлэлийн өсөлт нь эхний улиралд хийгдсэн томоохон капитал хөрөнгө оруулалт болох хөвөн шарах камерийн технологийн шинэчлэлийн ажлын үр дүн байв.

2021 онд базальт лайт маркийн чулуун хөвөн хавтанг зах зээлд шинээр нэвтрүүлэн хэрэглэгчийн гарт хүргэсэн ба Стратегийн томоохон ач холбогдол бүхий байгууллагууд болох ДЦС-2 ТӨХК, ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК, УБДЦС ТӨХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ДЦС, Эрдэнэтийн ДЦС, Таван толгой түлш ХХК-д шугам хоолон дулаалга, төмөр торон бүрээстэй оёмол хөнжил зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн нийлүүлж чулуун хөвөн дулаалгын материал үйлдвэрлэх дотоодын цор ганц үйлдвэр гэдгээ баталж чадсан.

Гүйцэтгэх удирдлагын баг цаг үеийн нөхцөл байдалд зохицсон санхүү болон үйлдвэрлэл үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт хийн компанийн цаашдын үйл ажиллагааг тогтвортой байлгах бизнес төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл явуулахыг нэн тэргүүний зорилгоо болгон ажиллаж үйл ажиллагааны зардлаа 2020 онтой харьцуулахад 16%-иар бууруулан, борлуулалтын орлогоо 3.5 дахин, цэвэр ашигааа 11.7 дахин тус тус өсгөсөн амжилттайгаар 2022 оныг угтаж байна.

“Монгол базальт” ХК 2021 онд нийгмийн хариуцлагын хүрээнд олон төсөлт ажлуудыг зохион байгуулж, санхүүжүүлж оролцсоноос Өсвөрийн хоккейн улсын аварга шалгаруулах “Basalt cup 2021” уралдаан, “Мөрөөдөл биелдэг юм” хандив тусламж зэргийг дурьдаж болох юм.

Мөн тасралтгүй инноваци, судалгааны үр дүнд Хөрсгүй тариалалт буюу «Базальт Чулуун Хөвөн ашиглан ургамал тарих» гарын авлага ном гаргаж, Мишээл худалдааны төвд Showroom байгуулан экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, эко бүтээгдэхүүн хэрэглэх хүсэлт, зорилго бүхий хүмүүсийн хэрэгцээг хангахад гар бие оролцож байна.

Энэ бүгдээс дүгнэхэд Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг нь цаг үеийн нөхцөл байдалд тохируулан санхүү болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт хийж 2021 оны бизнес төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж чадварлаг ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

## МОНГОЛ БАЗАЛЫТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

# МОНГОЛ БАЗАЛЫТ ХУВЬЦААТ КОМПАНИ

“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2022 оны 03 сарын 10-ны өдрийн 4 тоот тогтоолын Хавсралт № 4

## “Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог .....нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар.....

Регистерийн дугаар .....

Санал өгөх хувьцааны тоо .....

“Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 22-  
ны өдрийн 14.00 цагт

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, тогтоолын төслийг батлах			

(Та саналыг хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдэгийг бичнэ үү)

Хувьцаа эзэмшигч .....Гарын үсэг

Бүртгэсэн / Үнэт цаасны компани / .....

Брокерийн овог ..... нэр .....

Брокер .....

/ тэмдэг /

2022 оны ..... сар.....өдөр

### САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч үнэт цаасны компани (ҮЦК)дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.
3. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын талаарх мэдээллийг 75114444, 99804164 утсаар лавлаж болно.

Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан.....

Тооллогын комиссын гишүүн.....

**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ/төсөл/**

2022 оны 04 сарын 22 -ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

*Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн  
талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монгол  
Базалт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11 дэх заалт, 2022 оны 04 сарын 22-ны өдрийн хувьцаа  
эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базалт” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх Төлөөлөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг  
баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

А.ЭНХГЭРЭЛ



**МОНГОЛ БАЗАЛТ ХК**  
ЖИЛ ИННОВАЦИ ТЕХНОЛОГИ



**BASALTWOOL**  
ГАЛД ШАТДАГГУЙ  
ДУЛААН ТУСГААРЛАГЧ

**БАЗАЛИТ FLEX**  
УЯН АКУСТИК  
ХАВТАН 


# 2021 оны үйл ажиллагааны тайлан

**BASWOOL**  
*Farm*  
БАЗАЛТ ХӨВӨН ХӨРС  
НОГООН ТАРИАЛАЛТ



SUSTAINABLE DEVELOPMENT GOALS

*Bagi Max*  
PHOTOGRAPHY



## АГУУЛГА

01	<i>Гүйцэтгэх захирлын мэндчилгээ</i>	01
02	<i>Компанийн тухай</i>	02
03	<i>Хүний нөөц</i>	06
04	<i>Хувьцааны мэдээлэл</i>	07
05	<i>Санхүү байдлын гол үзүүлэлтүүд</i>	08
06	<i>Оролцсон үзэсгэлэн арга хэмжээ</i>	10
07	<i>Нийгмийн хариуцлага</i>	11
08	<i>Үйлдвэрлэл технологийн ажлууд</i>	13
09	<i>ХАБЭА</i>	14
10	<i>Компанийн засаглал</i>	15
11	<i>Санхүүгийн тайлан</i>	17

# Компанийн тухай



## Ерөнхий мэдээлэл

Компанийн оноосон нэр:	"Монгол Базальт" ХК
Байгуулагдсан огноо:	2007
Үйл ажиллагааны чиглэл:	Чулуун хөвөнгийн үйлдвэр
Албан ёсны хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр, 403 тоот
Утас:	(976) 75114444
Вэб:	www.basaltwool.mn
E-mail:	monbasalt@rockwool.mn
Фэйсбүүк:	Mongol Basalt JSC

## Удирдлага, хүний нөөц

ТУЗ-ийн дарга:	Л.Ариунболд
Гүйцэтгэх захирал:	А.Энхгэрэл
Ажилчдын тоо:	75

## Үйлдвэрлэл

Үйлдвэрийн хүчин чадал:	Цагт 1.8 тн
-------------------------	-------------

## Хувьцааны мэдээлэл

Хувьцааны симбол код:	MSE:MBW / 544
МХБиржид бүртгэгдсэн:	2018.04.05
Нийт гаргасан хувьцаа:	56,417,000 ширхэг
Хувьцааны ханш:	172.41 төгрөг /2021.12.31/

# Эрхэм зорилго



ИННОВАЦИ ШИНГЭСЭН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИОРОО САЛБАРАА  
МАНЛАЙЛАН ХӨГЖҮҮЛЖ, ХҮНИЙ АМЬДРАХ ОРЧИНГ ЭРҮҮЛ ТАВ  
ТУХТАЙ, БАЙГАЛЬ ДЭЛХИЙД ЭЭЛТЭЙ, БАРИЛГА ХИЙЦИЙН ЭРСДЭЛГҮЙ  
ИРЭЭДҮЙ ХОЙЧДОО ӨВЛҮҮЛЭН ҮЛДЭЭХ, ЯМАГТ ӨСӨХ ҮНЭ ЦЭНЭ  
БАТАЛГААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ БИЙ БОЛГОХ.



## Уриа үг


*Нэг чулууны долоон гайхамшиг*

*Бидний бүтээгдэхүүний цөмд байгалийн  
чулууны хүч оршино.*





# Бүтэц зохион байгуулалт





**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
АРИУНБОЛД ЭНХГЭРЭЛ**



**П.БАТМӨНХ**

Албан тушаал: Үйлдвэр эрхэлсэн захирал  
Мэргэжил: Технологийн инженер



**Ц.БАЙГАЛМАА**

Албан тушаал: Дотоод хяналтын ажилтан  
Мэргэжил: Нягтлан Бодогч/Дотоод  
хяналтын мэргэшсэн аудитор



**П.БААСАН-ОЧИР**

Албан тушаал: Үйлдвэрийн дарга,  
ерөнхий технологич  
Мэргэжил: Технологийн Инженер  
мэргэжилтэй.



**Х.БАТДЭЛГЭР**

Албан тушаал: ИТА-ны ерөнхий инженер  
Мэргэжил: Цахилгааны инженер



**Б.БОЛОРТУЯА**

Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч  
Мэргэжил: Нягтлан Бодогч




## Хүний нөөц

"Монгол базальт" ХК нь удирдлага санхүүгийн 26, үйлдвэрийн ИТА-17, үйлдвэрийн ажилтан 32, нийт 75 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа ба нэг ээлжиндээ 8-10 цагийн ажилтан ажиллуулдаг.

## Ажилласан жил

10-с дээш жил  
15%



Нийт ажилтнуудын 27.5 хувь нь эмэгтэй, 72.5 хувь нь эрэгтэй бөгөөд 73 хувь нь 20-50 насны идэвхитэй хөдөлмөр эрхлэгчид юм. Ажилтнуудын боловсролын бүтцийг авч үзвэл 22% нь бүрэн дунд ба тусгай мэргэжлийн, 78% нь дээд боловсролтой бөгөөд үүнээс магистрант 1, доктор зэрэгтэй 1 ажилтан тус тус байна.

<p>АЖИЛЧДЫН ТОО</p> <p><b>75</b></p> <p>АЖИЛЧДЫН ТОО</p>	<p>АЛБА ХЭЛТЭС</p> <p>Захиргаа-20</p> <p>Үйлдвэр-49</p> <p>Борлуулалт-6</p>
<p>ХҮЙСИЙН ХАРЬЦАА</p> <p><b>72.5%</b></p> <p><b>27.5%</b></p>	<p>НАСНЫ БҮТЭЦ</p> <p>50-с дээш нас 27%</p> <p>30-40 нас 30%</p> <p>20-29 нас 43%</p>

# Хувьцааны мэдээлэл


## Хувьцааны ханш

Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 249.53₮, доод ханш нь 160.11₮ байсан бол 2021 оны хаалтын ханш 172.41₮ байлаа.

Хувьцааны дээд ханш 249.53₮

Хувьцааны доод ханш 160.11₮

## Хувьцааны ханшийн график




## Хувьцааны арилжаа

"Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээл 2.778 сая ширхэг хувьцаа 496.77 сая төгрөгөөр арилжигдлаа.

Сар	Арилжаалагдсан тоо хэмжээ (мянган ширхэг)	Үнийн дүн (мянган төгрөг)
1	153.19	26,903.45
2	312.40	56,185.97
3	272.96	48,913.17
4	263.16	45,556.29
5	127.30	21,082.18
6	79.37	13,226.00
7	94.21	15,738.99
8	391.02	66,011.90
9	328.49	69,023.75
10	113.34	22,020.74
11	201.52	36,072.27
12	441.27	76,034.44

## Хувьцаа эзэмшигчид



- 5%-с дээш хувьцаа эзэмшигчид 70%
- 5%-с доош хувьцаа эзэмшигчид 30%

# Санхүү байдлын гол үзүүлэлтүүд

13.9%

Цэвэр ашиг

22.5%

нийт хөрөнгийн  
өсөлт


## Санхүү байдал

"Монгол Базальт" ХК нь 2021 оны эхний хагас жилд цар тахлын эрсдэлийг даван туулж, үйл ажиллагаагаа явуулсанаар зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахын төлөө чармайн хичээл зүтгэл гаргаж их бүтээн байгуулалтыг өрнүүлж ажилласны үр дүнд нийт хөрөнгө 22.5% цэвэр ашгийн түвшин өмнөх оны мөн үед 5.01% байсан бол 2021 онд 13.9%-д хүрлээ


## Ашигт ажиллагаа

"Монгол Базальт" ХК нь 2021 онд борлуулалтын орлогоо өмнөх оны мөн үеэс 3.53 дахин нэмэгдүүлэн 11.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллалаа. 2020 онд нийт борлуулалтын орлогын 26.3% нь борлуулалт удирдлагын зардал эзлэж байсан бол 2021 онд 12.4% болгон амжилттай бууруулав.

Борлуулалт удирдлагын зардал



Борлуулалтын орлого (сая.төг)




# Санхүү байдлын гол үзүүлэлтүүд

Х 3.53

Борлуулалтын орлогын өсөлт

## Чулуун хөвөнгийн борлуулалт / Боодлоор



2021 онд борлуулалт маркетингийн алба нийт 251,043 боодол чулуун хөвөн худалдан борлуулсан байна. Чулуун хөвөн дулаалгыг зузаанаар нь ангилан авч үзвэл 5 см-ийн зузаантай чулуун хөвөн 104,775 боодол буюу 18,860 м<sup>3</sup>, 7.5 см-ийн зузаантай чулуун хөвөн 39,377 боодол буюу 7,088 м<sup>3</sup>, 10 см-ийн зузаантай чулуун хөвөн 96,905 боодол буюу 23,257 м<sup>3</sup>, 15 см-ийн зузаантай чулуун хөвөн 9,988 боодол буюу 1798 м<sup>3</sup> нийт 51,000 м<sup>3</sup> чулуун хөвөн дулаалгын материалыг худалдан борлуулсанаас 582 аж ахуй нэгж байгууллага 1,200 гаруй иргэн худалдан авалт хийсэн байна.

2021 онд базальт лайт маркийн чулуун хөвөн хавтанг зах зээлд шинээр нэвтрүүлэн хэрэглэгчийн гарт хүргэсэн байна. Стратегийн томоохон ач холбогдол бүхий байгууллагууд болох ДЦС-2 ТӨХК, ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК, УБДЦС ТӨХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ДЦС, Эрдэнэтийн ДЦС, Таван толгой түлш ХХК-д захиалсан бүтээгдэхүүнийг цаг хугацаанд нь найдвартай ханган нийлүүлж ажиллалаа.

# Оролцсон үзэсгэлэн арга хэмжээ

## ӨНТЭЙ ӨВӨЛЖЬЕ

Нийслэлийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “ӨНТЭЙ ӨВӨЛЖЬЕ” үзэсгэлэн арга хэмжээнд оролцож шинэ бүтээгдэхүүний танилцуулга хийн иргэдийг чулуун хөвөн дулаалгын материалыг ашиглан амьны орон сууц дулаалах зөвлөгөө мэдээллээр хангав.



## Улаанбаатар барилга 2021


Жил бүр Мишээл барилгын их дэлгүүр дээр зохион байгуулагддаг "Улаанбаатар барилга 2021" үзэсгэлэнд оролцон шинэ бүтээгдэхүүний танилцуулга хийлээ. Мөн чулуун хөвөн хавтан, шугам хоолойн дулаалга, базальт арматур, хөрсгүй тариалалтын бүтээгдэхүүн хэрэглэгч, хамтран ажиллагч байгууллагууддаа танилцуулж, мэдээлэл зөвөлгөөг хүргэлээ.

# Нийгмийн хариуцлага



## Basalt hockey cup 2021

Өсвөрийн хоккейн улсын аврага шалгаруулах тэмцээнийг "Монголын ирээдүй болсон хүүхэд багачуудынхаа төлөө бид зүтгэнэ" уриан дор амжилттай зохион байгуулав.



## Гар зургийн уралдаан

"Монгол Базальт" ХК-ийн 30-н жилийн ойн хүрээнд Олон улсын хүүхдийн эрхийн өдрийг тохиолдуулан "ДУЛААХАН БАЙШИН НОГООН ХОТ" сэдэвт хүүхдийн гар зургийн уралдаан амжилттай зохион байгууллаа.



## Фэйсбүүк азтан

"Монгол Базальт" ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд фэйсбүүк фэйж хуудас дагагчдын дунд "Байраа дахин дулаалъя" сэдэвт уралдаан зарлаж азтанг Базальтвүүл чулуун хөвөн дулаалгын материал авах эрхийн бичгээр урамшуулав.



## Хандив тусламж

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвд хоёр хүнд зэрэг ашиглах боломжтой #YUWELL9F3AW загварын хүчилтөрөгчийн амьсгалын аппарат, ЕБС-д гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмж болон хэвлэх хувилах төхөөрөмж хүлээлгэн өгөв.



# Нийгмийн хариуцлага

## Мөрөөдөл биелдэг юм

Монгол базальт ХК-ийн хамт олон Араг продакшн ТВ9 телевизийн хамтран бэлтгэдэг "Мөрөөдөл биелдэг юм" төсөлд хамтран ажиллаж Онцгой байдлын албан хаагч Ж.Пүрэвдэмбэрэлийн байр сууцыг дулаалах дулаалгын материал хандивлалаа.



## Хөрсгүй тариалалт

"Базальт Чулуун Хөвөн ашиглан ургамал тарих" гарын авлага зааварчилгааны номоо хэрэглэгчидийн гарт хүргэж номын нээлтийг Мишээл барилгын их дэлгүүрт байрлах Showroom-д зохион байгуулав.



# Үйлдвэрлэл технологийн ажлууд



"Монгол базальт" ХК-ийн дулаан тусгаарлагч материалын үйлдвэр нь 2021 оны эцсийн байдлаар 18 удаагийн үйлдвэрийн тасралтгүй хөдлөлтөөр 3033.1 тонн хөвөн үйлдвэрлэсэн.

Шугам хоолойн үйлдвэрт нийт 4,129 метр шугам хоолой, яндан хоолойн дулаалга үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн.



"Монгол Базальт" ХК-ийн дулаан тусгаарлагч оёмол хөнжлийн цехд 2021 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Дулааны цахилгаан станцын захиалгаар Ф325-н 10 см-н зузаантай 120 метр, Ф426-н 10 см-н зузаантай 150 метр оёмол хөнжил хийж нийлүүлсэн ба бусад хэрэгдэгчдэд 174 метр 5 см-н зузаантай төмөр торон бүрээстэй оёмол хөнжил үйлдвэрлэн нийлүүлсэн.



---

## ХАБЭА

"Монгол Базальт" компанийн технологийн албанаас 2021 онд Хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол түүнээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг сар бүр тогтмол зохион байгуулж нийт ажилчдыг хамруулав.

### **“Хувийн Хамгаалах Хэрэгсэл” Сургалтын хөтөлбөр**

Сургалтын хөтөлбөр нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Ерөнхий мэдлэг
- Туршилт, судалгаа
- Зөвөлгөө, мэдээлэл

Уг сургалтын ач холбогдол нь:

- Ажлын байран дахь аюулын үнэлгээний талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй болох буюу “яагаад” хувийн хамгаалах хэрэгсэл чухал вэ? гэдгийг ойлгох.
- Хувийн хамгаалах хэрэгслийн оновчтой зөв хэрэглээ, түүний шаардлага.
- Хувийн хамгаалах хэрэгсэл зөв арчилгаа, засвар болон устгал Ажлын байранд “ Эрсдэл аюулын үнэлгээ”-г хийж сурах зэрэг болно.



# Компанийн засаглал

## Хараат бус гишүүд



### **ШАРАВСАМБУУ ЭНХТӨР**

Мэргэжил: Эрх зүйч,  
Банкны удирдлага



### **ЧАНСАА ЗОРИГТБААТАР**

Мэргэжил: Хуульч,  
эдийн засагч



### **ПҮРЭВСҮХ НЯМДОРЖ**

Мэргэжил: Бизнесийн  
удирдлага, компаний  
засаглалын эксперт,  
эдийн засагч

Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь “Компанийн тухай хууль” болон “Монгол Базальт” ХК-ийн дүрэмд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага юм.

ТУЗ нь компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийн эрхийг компанид төлөөлөн хамгаалдаг.

ТУЗ нь жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг тогтмол хянан, холбогдох үүрэг, чиглэлийг гүйцэтгэх удирдлагад өгч ажилладаг.

“Монгол Базальт” ХК-ийн одоогийн ТУЗ нь 2021 оны 04 сарын 26-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдон ажиллаж байна.

ТУЗ нь дэргэдээ дараах 3 дэд хороотой үйл ажиллагаагаа явуулж ба “Монгол Базальт” ХК-ийн 2021 оны 5 сарын 31-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэлдэхүүнтэй томилогдон ажиллаж байна.

## **ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД**

### **1. Аудитын хороо**

Дарга: Б.Шаравсамбуу  
гишүүд: Ч.Зоригтбаатар, Ш.Энхтөр

### **2. Нэр дэвшүүлэх хороо**

Дарга: Г.Ганзориг  
гишүүд: Хан Гю Бунг, П.Нямдорж,  
П.Сайнбилэг

### **3. Цалин урамшууллын хороо**

Дарга: П.Нямдорж  
Гишүүд: Ч.Зоригтбаатар, А.Энхгэрэл

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд



**ЛХАГВАЖАВ АРИУНБОЛД**

Мэргэжил:

Цахиурын исэлд суурилагдсан эрдэсийн хайлах болон дулаанаар боловсруулах технологийн үйлдвэрийн инженер, Эдийн Засагч, Үйлдвэрийн гавьяат ажилтан /Техникийн Ухааны доктор, Аж Ph.D доктор/



**АРИУНБОЛД ЭНХГЭРЭЛ**

Мэргэжил:

Үйлдвэр Үйл ажиллагааны Менежмент,  
Санхүү Менежмент



**ГАЛБАДРАХ ГАНЗОРИГ**

Мэргэжил: Цэргийн командлагч, Улс төр судлаач



**БАДРАХ ШАРАВСАМБУУ**

Мэргэжил:

Нягтлан бодогч, Гавьяат Эдийн засагч,  
/ PhD Доктор, Эдийн Засгийн Ухааны Доктор /



**ПҮРЭВБАНЗРАГЧ САЙНБИЛЭГ**

Мэргэжил: Технологийн Инженер, Санхүүч



**HAN KYU BONG /ХАН ГЮ БУНГ/**

Мэргэжил: Бизнес удирдлагын мастер

# Санхүүгийн тайлан

Санхүү байдлын тайлан  
/мян.төг/

Мерийн дугаар	Балаасын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1.1	Мөнгө түүнтэй адилгах хөрөнгө	860,235.40	5,964,104.88
1.1.2	Дансны авлага	1,106,308.62	4,887.22
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	155.42
1.1.4	Бусад авлага	68,719.38	114,042.20
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	933,235.55	2,425,087.30
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	871,523.38	653,897.65
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	184,939.20	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.10	...	0.00	0.00
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>4,024,961.55</b>	<b>9,162,174.67</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	14,244,884.37	15,562,794.68
1.2.2	Биет бус хөрөнгө	12,924,332.08	13,503,921.06
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.9	...	0.00	0.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>27,169,216.45</b>	<b>29,066,715.74</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>31,194,177.99</b>	<b>38,228,890.41</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.1.1	Дансны өглөг	190,447.28	181,381.67
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	292,938.82	1,104,502.92
2.1.1.4	НДШ-ийн өглөг	27,643.20	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	1,882,100.00	5,900,141.67
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	130,323.43	130,323.43
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	9,101.34	1,054,622.74

# Санхүүгийн тайлагнал

## Санхүү байдлын тайлан /мян.төг/

2.1.1.8	Урьдчилж орсон орлого	9,101.34	1,054,622.74
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	145,291.74	180,328.32
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	16,001.96	1,405.58
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.12	...	0.00	0.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,693,847.77</b>	<b>8,552,706.32</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,432,176.17	0.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон гатварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.5	...	0.00	0.00
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,432,176.17</b>	<b>0.00</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>4,126,023.93</b>	<b>8,552,706.32</b>
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	0.00	0.00
2.3.2	Хувийн өмч	5,641,700.00	5,641,700.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	20,509,765.23	20,509,765.23
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	1,429,273.95
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	916,688.83	2,095,444.91
2.3.10	...	0.00	0.00
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>27,068,154.06</b>	<b>29,676,184.09</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>31,194,177.99</b>	<b>38,228,890.41</b>


# Санхүүгийн тайлагнал


Дэлгэрэнгүй орлогын  
тайлан /мян.төг/

Мөрний дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>3,246,997.46</b>	<b>11,485,330.45</b>
2	<b>Борлуулалтын өртөг</b>	<b>2,123,004.58</b>	<b>7,488,968.62</b>
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>1,123,992.89</b>	<b>3,996,361.82</b>
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүгийн орлого	75,942.92	77,088.12
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	4,674.37	3,373.29
9	Борлуулалт, маркетингийн зардал	432,531.39	733,235.30
10	Ерөнхий ба удирдлагын зардал	422,560.31	694,761.58
11	Санхүүгийн зардал	107,422.36	507,235.76
12	Бусад зардал	43,181.49	287,401.45
13	<b>Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )</b>	<b>-527.61</b>	<b>2,138.86</b>
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз ( гарз )	0.00	0.00
17	<b>Бусад ашиг ( алдагдал )</b>	<b>-12,023.98</b>	<b>0.00</b>
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>186,363.03</b>	<b>1,856,328.02</b>
19	Орлогын татварын зардал	23,639.58	254,261.98
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>162,723.45</b>	<b>1,602,066.04</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>162,723.45</b>	<b>1,602,066.04</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	1,429,273.95
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	1,429,273.95
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз ( гарз )	0.00	0.00
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>162,723.45</b>	<b>3,031,339.99</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>





 "Фламинго тауэр" 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Улаанбаатар хот, Монгол улс

 75114444

 [www.Basaltwool.mn](http://www.Basaltwool.mn)

 [Monbasalt@Rockwool.mn](mailto:Monbasalt@Rockwool.mn)

 Mongol Basalt JSC

 @Mongol\_Basalt

 Mongol\_Basalt